



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/54

Модот

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах
тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/125 дугаар тушаал, Хэнтий аймгийн мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/26 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээний бүх үхэр, гахайг хамруулан 2025 оны 04 дүгээр сарын 25-ноос 25 хоногийн хугацаанд Дэрст хайрхан ХХК, Цэнхэр бэлчир ХХК, Үржих баян мандал ХХК-ний мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд шуурхай зохион байгуулахыг даалгасугай.

2.Дархлаажуулалт хийх ажлыг малчдад урьдчилан мэдэгдэж мал сүргийг бэлэн байлгаж, бүрэн хамруулах, тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх ажлыг Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардлагатай вакцин татан авах, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт хийх, нэгдсэн тайлан дүн мэдээг Мал эмнэлгийн газарт хүргэж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (П.Ганчимэг)- т хариуцуулсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ